



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 41

Чойр

“Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийг
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “ж”, 25 дугаар зүйлийн 25.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жил бүр тайлагнаж байхыг аймгийн Засаг дарга /Г.Батсуурь/-д даалгасугай.

ДАРГА



Г.БАТЗАМ



“ХҮНСНИЙ НОГОО” ДЭД ХӨТӨЛБӨР **/2019-2022 он/**

Нэг. Нийтлэг үндэслэл

Өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор Засгийн газар “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөрийг 1997-2012 онуудад 2 үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2012 онд 8.9 га-д төмс, хүнсний ногоо тариалж 61 тн ургац хураан авч хэрэгжүүлсэн хугацаанд тариалсан талбай 66,3 хувь, ургац 78,7 хувиар нэмэгдсэн байдаг.

2017 онд 34 иргэн аж ахуй нэгж, байгууллага төмс, хүнсний ногоо тариалж 17.2 га талбайгаас 100.5 тн төмс, 17.2 га талбайгаас 140.5 тн хүнсний ногоо хураан авсан нь 2012 онтой харьцуулахад төмс, хүнсний ногоо тариалсан талбай 2.4 дахин, хураан авсан ургацын хэмжээ 3 дахин нэмэгдэж, хүн амын төмсний хэрэгцээний 15 хувь, хүнсний ногооны хэрэгцээний 15 хувийг орон нутгийн ургацаас хангадаг болоод байна.

Хүнсний ногооны үйлдвэрлэл нь гар ажиллагаа ихтэй, нарийн технологитой, шинэ технологи нэвтрүүлэхэд өртөг өндөртэй байдаг. Манай аймагт хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшин 15 хувьтай байгаа бөгөөд нийт тариалан эрхлэгчдийн 21.3 хувь нь талбайгаа услалтын системээс, 78,7 хувь нь талбайгаа энгийн аргаар усалж байна. Түүнчлэн нийт үйлдвэрлэлийн 0,9 хувь буюу 0,3 га талбай бүхий 33 хүлэмжид тариалалт хийж 7.5 тн өргөст хэмх, улаан лооль, чинжүү зэрэг хүнсний нарийн ногоо хураан авч орон нутгийн иргэдийн хэрэгцээнд 9,68 тн бүтээгдэхүүн нийлүүлж байгаа нь хангалтгүй байна.

Иймд манай аймаг өрхийн тариалан эрхлэгчдээс гадна 0.1 га-аас дээш талбайд төмс, хүнсний ногоо тариалахыг дэмжих замаар нийт үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, усалгааны дэвшилтэт аргыг нэвтрүүлэх, техник тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүнийг хадгалах агуулах, зоорийн тоог нэмэгдүүлж стандартыг хангуулах,

төмс, хүнсний ногооны хэрэгцээний 20-оос доошгүй хувийг орон нутгийн үйлдвэрлэлээс хангах цаашид нэмэгдүүлэх, үлдсэн 80 хувийг стандартын шаардлага хангасан зоорь, агуулахаас нийлүүлэх шаардлага гарч байна.

Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт “Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ” гэж заасны дагуу “Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. **Хөтөлбөрийн зорилго нь:** аймгийн хүн амын нийт хэргцээний 20-оос доошгүй хувийг орон нутгийн үйлдвэрлэлээс хангаж цаашид нэмэгдүүлэх, шаардагдах эрэлт хэрэгцээг дотоодын үйлдвэрлэгчдийн стандартын шаардлага хангасан зоорь, агуулахад хадгалсан, гарал үүсэл нь тодорхой, чанар эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр жилийн турш тогтвортой хангахад оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1. Хамгаалагдсан хөрсний тариаланг дэмжиж таримлын нэр төрлийг олшруулах, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх;

2.2.2. Төмс, хүнсний ногооны тариалалтад дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;

2.2.3. Усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх;

2.2.4. Агуулах, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулах, шууд худалдааг дэмжин хөгжүүлэх;

2.2.5. Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхийг сайжруулах.

Гурав. Хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Хөтөлбөрийн 2.2.1-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. Өвлийн болон нарлаг хүлэмж барих үүсгэл санаачлагыг зээлийн дэмжлэгт хамруулж, хүн амыг шинэ ургацын ногоогоор хангах хугацааг уртасгана.

3.1.2. Зуны нийлэг хальсан хүлэмж байгуулах үүсгэл санаачлагыг зээлийн дэмжлэгт хамруулах ажлыг зохион байгуулна. Таримлын нэр төрлийг нэмэгдүүлнэ.

3.1.3. Хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, таримлын ургалтын үеийн био, органик, эрдэс бордоог хэрэглэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.2. Хөтөлбөрийн 2.2.2-т заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. Ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх, зохистой дадал, шинэ технологийг нэвтрүүлэх замаар химийн бодисын хэрэглээнээс зайлсхийнэ.

3.2.2. Хүнсний ногооны тариалалт, хураалт, хадгалалтын технологийг хөрс, бордоо, ургамал хамгаалал, сорт, усжуулалт, механикжуулалт, хадгалалт, тээвэрлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй хамтад нь авч үзэн цогцоор нь зөвлөмж болгон боловсруулж, тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид нэвтрүүлнэ.

3.2.3. Хүнсний ногоо үйлдвэрлэгчдэд бага оврын трактор, түүнд зориулсан чиргүүл дүүжин машин, мотоблок болон түүнд сольж угсардаг үрлэх, арчлах, хураах техникийн талаар арга зүй өгч мэдээллээр хангаж ажиллана.

3.2.4. Өрхийн тариалан эрхлэгчид сайн дураараа хорших, хуулийн этгээд байгуулах, нэгдсэн байдлаар техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад нь арга зүйн зөвлөгөө өгч холбогдох газарт уламжлан санхүү, эрх зүйн зөвлөмж болон зээл, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгт хамруулна.

3.2.5. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг арга зүйгээр ханган таримлын сэлгээ хийх санаачлагыг дэмжих замаар хөрсний шим тэжээлийг нэмэгдүүлэх;

3.2.6. Статистикийн албан ёсны мэдээлэлд хүнсний ногоог таримлын нэр төрлөөр оруулж, аймгийн мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлнэ.

3.3. Хөтөлбөрийн 2.2.3-т заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. Хүнсний ногоо тариалахад тохирсон эрчим хүчний зарцуулалт багатай, ус хэмнэлттэй зарцуулдаг, байгаль орчинд халгүй, хямд төсөр усалгааны арга болох дуслын усалгаа, хөрсөн дотроос нэвчүүлэх усалгаа зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.

3.3.2. Услалтын системд ногоо тарих үүсгэл санаачлагыг дэмжих замаар ногоочдын бүлэг, хоршоодыг байгуулан нэгж талбайгаас авах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх;

3.4. Хөтөлбөрийн 2.2.4-т заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1. Тариалан эрхлэгчдийн санаачлага, оролцоонд тулгуурлан хүнсний ногоог хадгалах, борлуулах шууд худалдааны борлуулалтын цэгүүд байгуулахыг дэмжинэ.

3.4.2. Хүнсний ногооны борлуулалтыг төрийн худалдан авалт (боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах болон уул уурхай)-аар дэмжинэ.

3.4.3. Таримлын төрөлд зохицсон зориулалтын зоорь, агуулах байгуулах иргэн аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлнэ. Байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй хөргөлт, халаалтын технологитой стандарт бүхий зоорийн аж ахуй байгуулахыг дэмжинэ..

3.4.4. Хүнсний ногоо тариалагчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ чанар, стандартад нийцүүлэн зах зээлд нийлүүлэх, борлуулалтын дотоод боломжийг нэмэгдүүлнэ.

3.5. Хөтөлбөрийн 2.2.6-д заасан зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.5.1. Газар тариалан эрхлэгчдийг мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн ногоочин, техникийн ажилтан бэлтгэх төрөлжсөн сургалтанд хамруулж, мэргэшүүлнэ.

3.5.2. Салбарт ажиллагсдыг үр үйлдвэрлэл, хүлэмжийн аж ахуй, усалгааны шинэ техник, зоорийн тоног төхөөрөмжтэй танилцуулах, улсын үзэсгэлэнд оролцуулах зэрэг арга хэмжээнд хамруулж, шинэ технологи зэмшүүлнэ.

3.5.3. Хамгаалагдсан хөрсний аж ахуй эрхлэгчдийг туршлага судлах, технологи нэвтрүүлэх, бусад аймаг, орон нутагт зохион байгуулах үзүүлэх сургалтанд оролцуулна.

3.5.4. Услалтын систем, усалгааны тоног төхөөрөмжийн ашиглалт, таримлын ус хэрэглээ, технологийн талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

3.5.5. Бага, дунд оврын техникийн ашиглалт, зориулалт, шатахуун зарцуулалт, бүтээлийн норм, технологийн сургалтыг танхимд болон талбайд зохион байгуулна.

3.5.6. Ногоочдыг сайн дурын зохион байгуулалтад оруулж, ургацаа төв суурин газарт борлуулах ажлыг мэргэжлийн холбоодын оролцоотой зохион байгуулж, үйл ажиллагааг сурталчилан таниулах ажлыг зохион байгуулна.

3.5.7. Дотоодод үйлдвэрлэх шим болон биологийн бордоог хэрэглэх, хөрсний үржил шимийг сайжруулах, хашаажуулах технологийн сургалтыг зохион байгуулна.

3.5.8. Хүнсний ногооны түгээмэл өвчин, хортон шавж, хог ургамлыг таних зорилго бүхий каталогийг хэвлүүлэн түгээх, хөнөөлт организмтай хүн, мал, амьтан, байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэх технологийн сургалт, семинарыг зохион байгуулна.

3.5.9. Хүнсний ногооны үйлдвэрлэлд ажиллаж байгаа залуу гэр бүл, залуучуудад гарааны болон санхүүгийн дэмжлэг олгоход арга зүйгээр ханган ажлын байртай болгох, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

3.5.10. “Алтан намар” үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулна.

Дөрөв. Хэрэгжүүлэх хугацаа

“Хүнсний ногоо” дэд хөтөлбөрийг 2019-2022 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

5.1.1. Улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2. Олон улсын болон хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

5.1.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив;

5.1.4. Бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дор дурдсан шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2018 он)	Хүрэх түвшин			
				2019	2020	2021	2022
1	Гол нэрийн хүнсний ногооны хангамж	хувь	15	16	17	18	20
2	Бага тархацтай буюу нарийн ногооны хангамж	хувь	0,9	1	1	1	1
3	Хүнсний ногооны нийт ургац	тонн	140	145	160	170	180
4	Хүнсний ногооны зоорийн хангамж	тонн	70	80	90	150	200
5	Нэгж талбайн ургац	цн/га	70	75	75	75	75
6	Хүнсний ногооны нэр төрөл, сорт	тоо	11 нэр төрөл, 11 сорт	11 нэр төрөл, 11 сорт	11 нэр төрөл, 11 сорт	11 нэр төрөл, 11 сорт	15 нэр төрөл, 15 сорт
7	Зоорины багтаамж	тонн	252	262	262	265	270
8	Хамгаалагдсан хөрсний ургац	тонн	9,5	10	11	12	15
9	Өвлийн болон нарлаг хүлэмж	М2	-	-	-	-	1
10	Нарны халаалттай болон нийлэг хальсан хүлэмж	М2	3500	3500	3500	3500	5000
11	Усалгаатай талбайн хэмжээ	га	30	30	30	30	30
12	Урт болон дунд хугацааны сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо	тоо	1	1	1	1	1
13	Ногоо тариалдаг өрх, аж ахуйн нэгжийн тоо	тоо	35	40	40	40	40
14	Өрхийн дундаж орлого /жил/	мян.төг	2,0	2,0	2,5	2,5	2,5

6.2. Хөтөлбөр хэрэгжих хугацааны шалгуур үзүүлэлтийн жил жилийн хүрэх түвшинг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ


7.1. Аймгийн Засаг даргын Тамгын газар, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл, зорилгоор зорилтуудыг хэрэгжүүлэхэд удирдлагаар хангах, дүн шинжилгээ хийх, хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

7.2. Хүнсний ногоо дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг Хүнс, хөдөө аж ахуйн газар удирдлага арга зүйгээр ханган, Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл урлагын газар, Сумдын Засаг даргын тамгын газрууд хамтран зохион байгуулж хасаг, бүтэн жилээр үр дүнг аймгийн Засаг даргын Тамгын газарт өөр өөрсдийн хариуцсан чиглэлээр тус тус тайлагнана.

7.3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь жил бүр хэрэгжилтийн төлөвлөгөө гарган, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийн, жилийн эцэст үр дүнг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана. 02 дугаар сарын 20-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ/

7.4. Хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 11 дугаар сарын 29-ны
өдрийн 41 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



“ХҮНСНИЙ НОГОО” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2018-2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая. Төг/	Хүрэх үр дүн, түвшин /хөрөнгийн эх үүсвэр/								Хэрэгжүүлэгч байгууллага	
				2019 он		2020 он		2021 он		2022 он		Үндсэн	Хамтрагч
				Хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Төсөв.сая/төг	Хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Төсөв.сая/төг	Хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Төсөв.сая/төг	Хүрэх үр дүнгийн үзүүлэлт, м2	Төсөв.сая/төг		
Нэг.Хамгаалагдсан хөрсний тариаланг дэмжиж таримлын нэр төрлийг олшруулах, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх													
Хүлэмжийн аж ахуйг дэмжиж, ургацыг нэмэгдүүлнэ	1	Эвлийн болон зуны хүлэмж барих үүсгэл санаачлагыг дэмжлэгт хамруулж, хүн амыг шинэ ургацын ногоогоор хангах кугацааг уртасгах.	2022 он 50,0 ХХО	-	-	-	-	-	-	20	50,0	ХАЭ	СЗДТГ ХХААГ АЗДТГ
Хоёр:Төмс, хүнсний ногооны тариалалтад дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;													
Газар тариалан эрхлэгчдийн техник үйлчилгээний цэгийг шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана.	2	Өрхийн тариалан эрхлэгчид сайн дураараа хорших, хуулийн этгээд байгуулах, нэгдсэн байдлаар техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад нь арга зүйн зөвөлгөө өгч холбогдох газарт уламжлан санхүү, эрх зүйн зөвлөмж болон зээл, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгт хамруулна.	2019-22 он	8	-	10	-	10	-	10	-	ХАЭ	СЗДТГ ХХААГ АЗДТГ

Гурав.Усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх;													
Усалгаатай газар тариаланг хөгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, нэгж га-аас авах ургацыг нэмэгдүүлнэ	3	Услалтын системд ногоо тарих үүсгэл санаачлагыг дэмжих замаар ногоочдын бүлэг, хоршоодыг дэмжин нэгж талбайгаас авах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх;	2019-22 он	40 га	-	40 га	-	45 га	-	45 га	-	ХАЭ	СЗДТГ ХХААГ АЗДТГ
	4	Хүнсний ногоо тариалахад тохирсон эрчим хүчний зарцуулалт багатай, ус зарцуулалт хэмнэлттэй, байгаль орчинд халгүй, хямд төсөр усалгааны тоног төхөөрөмжүүд авах хүсэлтэй иргэдийг арга зүйгээр ханган шаардлагатай мэдээллийг хүргэх.	2019-22 он 6.0 сая ХХО, ОНХС	2	1.5	2	1.5	2	1.5	2	1.5	ХАЭ	СЗДТГ ХХААГ АЗДТГ
Дөрөв. Агуулах, зоорийн багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулах, шууд худалдааг дэмжин хөгжүүлэх													
Стандартын шаардлага хангасан зоорь, агуулахын тоог нэмэгдүүлнэ	5	Хүнсний ногооны борлуулалтыг төрийн худалдан авалт (боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах болон уул уурхай)-аар дэмжинэ.	2019-22 он 40 сая УТ	10-аас доошгүй тн	10	10-аас доошгүй тн	10	10-аас доошгүй тн	10	10-аас доошгүй тн	10	ХАЭ	СЗДТГ ХХААГ АЗДТГ
	6	Зоорь, агуулах байгуулсан, засварласан иргэн аж ахуйн нэгжийг урамшуулж дэмжих.	2019-22 он 12 сая ОНХС	1 зоорь	3.0	1 зоорь	3.0	1 зоорь	3.0	1 зоорь	3.0	ХАЭ	СЗДТГ ХХААГ АЗДТГ

Тав. Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэдээллээр хангах замаар хүний нөөцийн чадавхийг сайжруулах.														
Усалгаатай газар тариаланг хөгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, нэгж га-аас авах ургацыг нэмэгдүүлнэ	7	Газар эрхлэгчдийг судлуулах, хийлгэх	тариалан туршлага дадлага	2019-22 он 2.0 сая ОНХС	5-аас доошгүй	0.5	5-аас доошгүй	0.5	5-аас доошгүй	0.5	5-аас доошгүй	0.5	ХАЭ	СЗДТГ ХХААГ АЗДТГ
	8	Ногоочдыг үзэсгэлэнд оролцуулах	улсын оролцуулах	2019-22 он 2.0 сая ОНХС	Улсын үзэсгэлэнд оролцуулах	0.5	Улсын үзэсгэлэнд оролцуулах	0.5	Улсын үзэсгэлэнд оролцуулах	0.5	Улсын үзэсгэлэнд оролцуулах	0.5	Сумдын МЭУТ ХХААГ	АЗДТГ
	9	Тариалан эрхлэгчдийг урамшуулах		2019-22 он 3.0 сая ОНХС	5-аас доошгүй	0.75	5-аас доошгүй	0.75	5-аас доошгүй	0.75	5-аас доошгүй	0.75	ХХААГ	СЗДТГ АЗДТГ
	10	Атрын 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх		2019 он	Ургацын баяр, Ойн арга хэмжээ	2.0	-	-	-	-	-	-	ХХААГ	СЗДТГ АЗДТГ
ДҮН					ОНХС-	8.95		6.95		6.95		6.95		
					ХХО-	50		50		50		50		
					УТ	50		50		50		50		

УТ- Улсын төсөв

ОНХС-Орон нутгийн хөгжил сан

ЖДҮДС- Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан

СХС- Сум хөгжүүлэх сан

ОУБТХ-Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрүүд